



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 27 өдөр

Дугаар 4/193

Дадал сум

Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээний
цахим дуудлага худалдааг зохион байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоол, Барилга хот байгуулалтын сайдын 2018 оны 208 дугаар тушаал, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 06 дугаар тогтоолын 06 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээний цахим дуудлага худалдааг 2024 оны 12 дүгээр сарын 30-ний өдрийн 09.00-15.00 цагийн хооронд зохион байгуулсугай.

2. Газруудын зориулалт, хэмжээ, анхны үнэ, дэнчингийн хэмжээ, эзэмшүүлэх хугацаа, дуудлага худалдаа эхлэх цагийн хуваарийг доорхи дурьдсанаар тогтоосугай.

- Баян-Овоо /4-р баг/ Цагаан даваа мод үржүүлгийн газар байгуулах зориулалттай 10000 м² газрын анхны үнэ 4800000 төгрөг, дэнчингийн хэмжээ 480000 төгрөг, Устай Цээнэтэйд мод үржүүлгийн газар байгуулах зориулалттай 5500 м² газрын анхны үнэ 2640000 төгрөг, дэнчингийн хэмжээ 264000 төгрөг, эзэмшүүлэх хугацаа 60 жил, дуудлага худалдаа 09 цаг 00 минутанд эхлэх,

3. Газрын цахим дуудлага худалдааг зохих хууль тогтоомжийн дагуу баримт бичгийг бүрдүүлж зохион байгуулахыг Газрын даамал (Б.Урансайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.МӨНХХУЯГ

010000461